

“Есөн Шижир Инвест ББСБ” ХХК нь үйл ажиллагаагаа олон улсын **ISO 9001:2015** (Чанарын удирдлагын тогтолцоо) болон **ISO 27001:2022** (Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо) стандартын шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлж, харилцагч болон сонирхогч талуудын сэтгэл ханамжийг өндөр түвшинд байлгах, байгууллагын тогтвортой хөгжил, үр ашигтай менежментийг дараах зорилтуудын хүрээнд хэрэгжүүлнэ.

1. Байгууллагын стратеги, зорилтыг хэрэглэгчийн хэрэгцээ, зах зээл болон хууль эрх зүйн орчинд нийцүүлэн тодорхойлно.
2. Удирдлагын манлайлал, хариуцлага, уялдаа холбоог бэхжүүлэх, ажилтнуудын мэдлэг чадварыг тасралтгүй дээшлүүлнэ.
3. Эрсдэл болон боломжийг цаг тухайд нь тодорхойлж, үр дүнтэй шийдвэр гаргах үйл явцыг хэрэгжүүлнэ.
4. Нэгдсэн менежментийн тогтолцоог бүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц, дэд бүтэц, хүний нөөцийн чадамжаар хангана.
5. Үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах, гүйцэтгэлийг тогтмол үнэлнэ.
6. Мэдээллийн нууцлал, хамгаалалт, аюулгүй байдлыг стандартын шаардлагын дагуу хангана.
7. Харилцагчийн сэтгэл ханамжийг дээд түвшинд байлгах, байгууллагын нэр хүнд, итгэлцлийг бэхжүүлнэ.